



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/680

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Баянцагаан жирэм” ХХК-ийн гүйцэтгэсэн “12 дугаар цэцэрлэгийн засварын ажил”-ыг ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын

дарга:

Б.Анхбаяр (Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Болортулга (Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

М.Баяржаргал (Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Түмэнжаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

С.Батдорж (Аймгийн архив албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч)

Б.Байгальмаа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн хяналтын инженер)

Ш.Гансүх (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн хяналтын инженер)

Н.Цэндсүрэн (“Баянцагаан жирэм” ХХК-ийн захирал)

8400001-5828

Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж (Газрын харилцаа барилга, хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн
мэргэжилтэн)

2. Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт “Баянцагаан жирэм”
ХХК-ийн гүйцэтгэсэн “12 дугаар Цэцэрлэгийн засварын ажил”-ыг ажлын тоо хэмжээ,
төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга
(Б.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.БАЯРТ

